



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/75

Өлгий

Эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэн жилийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

И.Айнагүл

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хариуцсан

Мэргэжилтэн

Гишүүд:

К.Жандаулет

Сэтгэцийн эрүүл мэнд, осол гэмтлийн тандалт хариуцсан

мэргэжилтэн

С.Еншигүл

Нярав

2. Эд хөрөнгийн тооллогыг 2024 оны 11 дүгээр сарын 15-аас 25-ны өдрийг хүртэл холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /И.Айнагүл/-т даалгасугай.

ДАРГА



Н.САКЕН